

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/321
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Энхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 14-нөөс 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Соёлын өвийн үндэсний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Эвиденсе Аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Соёлын өвийн үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Соёлын өвийн үндэсний төв нь Монгол үндэсний соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, бүртгэн баримтжуулах сэргээн засварлах хойч үедээ өвлүүлэн уламжлуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

1996 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 07 дугаар тушаалаар Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт, судалгаа хийх, сурталчилах, түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах, соёлын өвийг авран хамгаалах

Соёлын өвийн үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Соёлын өвийн үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Соёлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Соёлын өвийн үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Соёлын өвийн үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Соёлын өвийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Соёлын өвийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээ Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь АОУС320-ыг баримтлан санхүүгийн үр дүнгийн тайлан дахь нийт орлогыг сонгосонтой холбоотой.

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлого 608,269.6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 6,082.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 чиглэл 4 горимд залруулга гараагүй, 1 чиглэл 1 горим болон шинээр 1 чиглэлийн зөрчилтэй асуудал илэрснийг шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	27,917.3	
	Дүн	1	27,917.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд хураангуйлан тэмдэглэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Соёлын өвийн үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 457,480.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 441,862.1 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлын хэмнэлт гарснаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Соёлын өвийн үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Соёлын өвийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нэмэгдэл цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гэрээ байгуулалгүйгээр ажилтнуудад үндсэн цалин дээр нэмж төслийн санхүүжилтээс нэмэгдэл цалин 16 хүнд 27,917.3 мянган төгрөгний илүү цалин олгосон нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар “ Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх,хяналт тавих, үнэлэх журам” батлах тухай тушаалыг зөрчиж байна.

Эрсдэл:

Цалингийн зардал буруу илэрхийлэгдэх

Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг мөрдөж анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>126,007,547.28</u>	<u>190,191,579.00</u>
33	АВЛАГА	00.00	51,519,097.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	127,657.00
335	Бусад авлага	00.00	51,391,440.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	51,391,440.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	11,500,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	11,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	126,007,547.28	127,172,482.00
354	Хангамжийн материал	126,007,547.28	127,172,482.00
35410	Бичиг хэргийн материал	639,000.00	3,067,000.00
35420	Аж ахуйн материал	186,430.00	424,340.00
35430	Сэлбэг хэрэгсэл	320,000.00	320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	60,000.00	610,000.00
35450	Барилгын засварын материал	5,362,500.00	5,597,570.00
35470	Бусад хангамжийн материал	119,439,617.28	117,153,572.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>738,195,376.01</u>	<u>696,733,890.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	738,195,376.01	696,733,890.42
392	Биет хөрөнгө	719,920,375.42	573,107,956.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,000,000.00	10,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,600,000.10	-6,600,000.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	282,000,000.00	268,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-197,819,444.80	-199,577,778.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,464,081,744.48	1,482,277,944.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,051,018,597.81	-1,178,318,808.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	263,776,292.03	263,776,292.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,474,989.38	-72,270,115.02
39217	Ном	3,975,371.00	5,320,421.00
393	Биет бус хөрөнгө	18,275,000.59	123,625,934.42
39301	Програм хангамж	74,170,000.00	91,770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-55,894,999.41	-71,061,665.58
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	102,917,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>864,202,923.29</u>	<u>886,925,469.42</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>864,202,923.29</u>	<u>886,925,469.42</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	864,202,923.29	886,925,469.42
511	/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,094,306.63	796,011,906.63
51101	Өмч: - төрийн	693,094,306.63	796,011,906.63
512	Хуримтлагдсан үр дүн	171,108,616.66	90,913,562.79
51210	Өмнөх үеийн үр дүн	171,108,616.66	171,108,616.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-80,195,053.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>864,202,923.29</u>	<u>886,925,469.42</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	863,023,484.75	608,269,590.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	329,363,389.75	24,266,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	329,363,389.75	24,266,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	329,363,389.75	24,266,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	329,363,389.75	24,266,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	533,660,095.00	584,003,390.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	414,020,100.00	457,480,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	414,020,100.00	457,480,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	119,639,995.00	126,522,890.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	111,589,995.00	85,093,890.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,050,000.00	17,221,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	24,208,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	648,154,500.49	688,464,643.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	638,935,653.19	668,797,024.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	638,935,653.19	668,797,024.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,205,068.00	315,241,338.00
210101	Үндсэн цалин	287,263,268.00	228,932,183.00
210102	Нэмэгдэл	00.00	55,069,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,941,800.00	30,240,000.00
210104	Урамшуулал	00.00	999,555.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,219,431.00	38,581,508.00
210201	Тэтгэврийн даатгал	23,311,396.00	25,981,374.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,262,300.00	3,219,865.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,609,838.00	2,575,893.00
210204	Ажилгүйдлийн даатгал	639,627.00	615,976.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,396,270.00	6,188,400.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,466,317.00	27,512,627.61
210401	Бичиг хэрэг	1,788,380.00	2,067,180.00
210402	Тээвэр, шатахуун	10,378,500.00	9,586,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,425,753.70	3,874,097.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	83,140.00	941,660.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,790,543.30	11,043,290.28
2105	Нормативт зардал	00.00	1,409,840.00

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,409,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,937,000.00	9,374,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,972,100.00
210604	Урсгал засвар	10,937,000.00	7,402,440.00
2107	Томилолт, зочны зардал	8,543,470.00	3,188,000.00
210702	Дотоод албан томилолт	8,543,470.00	3,188,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,773,336.00	44,796,925.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,830,816.00	38,729,905.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,178,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	889,920.00	2,471,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	826,600.00	669,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	246,000.00
210807	Газрын төлбөр	905,000.00	680,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,529,731.19	207,430,945.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,883,300.00	7,410,610.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	155,646,431.19	200,020,335.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,218,847.30	19,667,619.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,400,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	818,847.30	18,867,619.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	818,847.30	18,867,619.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	214,868,984.26	-80,195,053.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	214,868,984.26	-80,195,053.87

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	552,341,977.00	584,003,390.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931,100.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	931,100.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	931,100.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	931,100.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	551,410,877.00	584,003,390.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	414,020,100.00	457,480,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	414,020,100.00	457,480,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128,719,495.00	126,522,890.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	120,669,495.00	85,093,890.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,050,000.00	17,221,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	24,208,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,671,282.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,671,282.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	522,143,977.00	552,628,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,143,977.00	552,628,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,925,129.70	481,569,280.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,876,350.00	315,241,338.00
210101	Үндсэн цалин	295,934,550.00	228,932,183.00
210102	Нэмэгдэл	00.00	55,069,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,941,800.00	30,240,000.00
210104	Урамшуулал	00.00	999,555.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,219,431.00	38,709,165.00
210201	Тэтгэврийн даатгал	23,311,396.00	26,109,031.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,262,300.00	3,219,865.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,609,838.00	2,575,893.00
210204	Ажилгүйдлийн даатгал	639,627.00	615,976.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,396,270.00	6,188,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,052,333.70	19,421,767.33
210401	Бичиг хэрэг	1,957,830.00	4,118,210.00
210402	Тээвэр, шатахуун	10,438,500.00	10,006,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,425,753.70	4,059,097.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	230,250.00	1,238,060.00
2105	Нормативт зардал	00.00	1,429,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,429,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,302,000.00	10,063,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	145,000.00	2,566,100.00
210604	Урсгал засвар	11,157,000.00	7,497,440.00
2107	Томилолт, зочны зардал	8,543,470.00	3,289,000.00
210702	Дотоод албан томилолт	8,543,470.00	3,289,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,855,845.00	64,653,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,913,325.00	58,586,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,178,000.00	2,000,000.00

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	889,920.00	2,471,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	826,600.00	669,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	246,000.00
210807	Газрын төлбөр	905,000.00	680,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,814,400.00	7,499,610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	931,100.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,883,300.00	7,499,610.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,218,847.30	71,059,059.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,400,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	818,847.30	70,259,059.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	818,847.30	70,259,059.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,198,000.00</u>	<u>31,375,050.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,198,000.00	31,375,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,198,000.00	31,375,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,198,000.00	31,375,050.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,198,000.00	31,375,050.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-30,198,000.00</u>	<u>-31,375,050.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,094,306.63	171,108,616.66	864,202,923.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,094,306.63	171,108,616.66	864,202,923.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	102,917,600.00	00.00	102,917,600.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн		-80,195,053.87	-80,195,053.87
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,011,906.63	90,913,562.79	886,925,469.42

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	457,480,500.00	441,862,080.33	15,618,419.67	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	457,480,500.00	441,862,080.33	15,618,419.67	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,680,500.00	441,062,080.33	15,618,419.67	96.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,958,900.00	270,893,648.00	13,065,252.00	95.4
210101	Үндсэн цалин	185,065,100.00	184,584,493.00	480,607.00	99.7
210102	Нэмэгдэл	67,653,800.00	55,069,600.00	12,584,200.00	81.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,240,000.00	30,240,000.00	0.00	100
210104	Урамшуулал	1,000,000.00	999,555.00	445.00	99.9
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	0.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,075,100.00	33,259,855.00	815,245.00	97.6
210201	Тэтгэврийн даатгал	22,716,700.00	22,460,218.00	256,482.00	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,839,600.00	2,763,676.00	75,924.00	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,271,700.00	2,210,940.00	60,760.00	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	567,900.00	529,547.00	38,353.00	93.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,679,200.00	5,295,474.00	383,726.00	93.24 %
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00	0.00	100
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	11,758,700.00	11,731,267.33	27,432.67	99.8
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,852,960.00	-852,960.00	142
210402	Тээвэр, шатахуун	2,629,200.00	2,616,400.00	12,800.00	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,966,000.00	3,678,797.33	1,287,202.67	74.1
210404	Ном, хэвлэл	1,517,500.00	1,345,050.00	172,450.00	88.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	646,000.00	1,238,060.00	-592,060.00	191
2105	Нормативт зардал	1,430,000.00	1,429,940.00	60.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.00	1,429,940.00	60.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,500,000.00	22,493,540.00	6,460.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	14,996,100.00	3,900.00	99.9
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,497,440.00	2,560.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,329,000.00	671,000.00	77.6
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,329,000.00	671,000.00	77.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,196,500.00	70,163,920.00	1,032,580.00	98.6

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,118,500.00	64,096,900.00	1,021,600.00	98.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	2,474,100.00	2,471,120.00	2,980.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	669,900.00	669,900.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	254,000.00	246,000.00	8,000.00	96.9
210807	Газрын төлбөр	680,000.00	680,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	7,499,610.00	390.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,500,000.00	7,499,610.00	390.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	0.00	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	0.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	0.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	457,480,500.00	441,862,080.33	15,618,419.67	96.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	457,480,500.00	441,862,080.33	15,618,419.67	96.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	457,480,500.00	441,862,080.33	15,618,419.67	96.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28	0.00	100
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.00	100

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.22	Аудитын нэр:	Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Соёлын өвийн үндэсний төв			Мянган төгрөгөөр	
				САГ-2019/386/СТА-ТШЗ	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Гэрээ байгуулалгүйгээр ажилтнуудад үндсэн цалин дээр нэмж төслийн санхүүжилтээс нэмэгдэл цалин 16 хүнд 27,917.3 мянган төгрөгний илүү цалин олгосон нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар “ Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх,хяналт тавих, үнэлэх журам” батлах тухай тушаалыг зөрчиж байна.	27,917.3	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ч.Өнөртогтох
	Дүн	27,917.3			

